



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/47

Улаанбаатар хот

Эд хөрөнгийн тооллого хийх комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 73 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 12.2.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын үндсэн эд хөрөнгө, материалын жилийн эцсийн тооллогыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- | | |
|-----------------------|---|
| Дарга: | Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга |
| Гишүүд: | Хүний нөөц, ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн |
| | Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод ажил хариуцсан Мэргэжилтэн |
| | Архив, бичиг хэргийн эрхлэгч |
| Нарийн бичгийн дарга: | Жуулчны аюулгүй байдал, мэдээллийн төвүүд хариуцсан менежер |

2.Комиссын гишүүдийг мэргэжлийн удирдлагаар хангаж тооллогыг 2025 оны 12 дугаар сарын 15-20-ны өдрүүдэд зохион байгуулахыг комиссын дарга (Д.Ганболд)-д даалгасугай.

ДАРГА

D. Batbayar

Д.БАТСҮХ





НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүрийн хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 87 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Хариуцлагатай жижүүрийн ажиллах журам батлах тухай” А/998 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бүх нийтийн амралтын өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан хуваарийн дагуу хууль, журамд нийцүүлэн үүрэг гүйцэтгэж, мэдээг холбогдох газарт тухай бүр хүргэж, удирдлагыг шуурхай мэдээллээр хангаж ажиллахыг хариуцлагатай жижүүрүүдэд үүрэг болгосугай.


3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж хариуцлагатай жижүүрээр ажиллах албан хаагчдыг нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж, баярын өдрүүдэд үүрэг гүйцэтгэсэн тухай тайлан, мэдээг 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр танилцуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2025 оны 12 дугаар сарын 19-ний
өдрийн 110 дугаар тушаалын хавсралт



БҮХ НИЙТИЙН АМРАЛТЫН ӨДРҮҮДЭД АЖИЛЛАХ ХАРИУЦЛАГАТАЙ
ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

2025 оны 12 дугаар сарын 19

Улаанбаатар хот

Д/д	Албан хаагчийн нэрс	Албан тушаал	2025 оны 12 сарын 29	2026 оны 01 сарын 01	Утас
1	2	3	4	5	6
Сүхбаатарын талбайн мэдээллийн төв					
1	Б.Билэгт	МТАжилтан			95017089
2	Г.Номинчимэг	МТАжилтан			80724899
Чингис хаан Олон улсын нисэх буудлын мэдээллийн төв					
1	Б.Багабанди	МТАжилтан			88609905
2	Б.Батжаргал	МТАжилтан			80034383



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Салбар ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засгийн газрын харьяа төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлдэг нэгжид чиг үүргийн шинжилгээ хийхэд шаардлагтай мэдээлэл бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий салбар ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

Гишүүд:

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга

Мэдээлэл сурталчилгааны хэлтсийн дарга

Хэвлэл мэдээлэл, олон нийтийн харилцаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Ахлах нягтлан бодогч

Нарийн бичгийн дарга:

Хүний нөөц, ёс зүй хариуцсан мэргэжилтэн

2.Байгууллагын дотоод үнэлгээг батлагдсан удирдамжийн дагуу үнэн зөв, бодит мэдээлэлд тулгуурлан, чанартай зохион байгуулж, үр дүнг танилцуулж тайлан мэдээг тогтоосон хугацаанд хүргүүлэхийг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-т даалгасугай

ДАРГА

D. Batbayar

Д.БАТСҮХ



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 14 сарын 30 өдөр

Дугаар А/50

Улаанбаатар хот

Албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэг, 52.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Аялал жуулчлалын газар”-ын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын 2025 оны ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээний мөнгөн урамшууллыг хавсралтын дагуу олгосугай.


2. Дээрх урамшуулалд шаардагдах 21,997,200 (Хорин нэгэн сая есөн зуун ерэн долоон мянга хоёр зуу) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТСҮХ



५ . चिन्तामणि

025060247


 תמונת אדם
 או חפץ אחר

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2025 оны 10 дугаар сарын 30-ны
өдрийн 1150 дугаар тушаалын хавсралт

АЛБАН ХААГЧДЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД
ӨГСӨН ҮНЭЛГЭЭ, УРАМШУУЛЛЫН ХУВЬ

д/д	Албан хаагчийн овог, нэр	Албан тушаал	Гүйцэтгэлийн үнэлгээ	Цалингийн хувь
1	2	3	4	5
1	Б.Цолмонгэрэл	Хэвлэл мэдээлэл, олон нийтийн харилцаа хариуцсан ахлах мэргэжилтэн	Маш сайн 99.1 %	100%
2	О.Нямбат	Бодлогын баримт бичгийн тайлан, тогтоол шийдвэр, үйл ажиллагааны хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн	Маш сайн 97.75%	100%
3	М.Мөнхцацрал	Жуулчны аюулгүй байдал, мэдээллийн төвүүд хариуцсан менежер	Маш сайн 95.7%	100%
4	Т.Батдорж	Эвент хариуцсан мэргэжилтэн	Маш сайн 95.3%	100%
5	Д.Ганболд	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга	Маш сайн 94.24%	100%
6	Ш.Ундармаа	Хүний нөөц, ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	Маш сайн 94.03%	100%
7	Б.Энхтайван	Цахим хөгжүүлэлт, мэдээллийн технологи хариуцсан ажилтан	Маш сайн 93.2%	100%
8	Ч.Энх-Отгон	Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	Маш сайн 92.5%	100%
9	С.Туул	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга	Маш сайн 92.48%	100%
10	Д.Долгоржав	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Маш сайн 91.62 %	100%
11	Н.Алтанзаяа	Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	Маш сайн 90%	100%
12	М.Цолмон	Эвент хариуцсан мэргэжилтэн	Маш сайн 88.26%	100%
13	Б.Халиун	Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөл хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн	Маш сайн 88%	100%
14	Д.Мөнхгэрэл	Ахлах нягтлан бодогч	Маш сайн 85.66%	100%



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

Эд хөрөнгө бүртгэж авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын А/416 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталж, нийт 127,850,000 (зуун хорин долоон сая найман зуун тавин мянга) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн холбогдох хууль, журмын дагуу бүртгэж авахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д үүрэг болгосугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөл (Д.Ганболд)-д даалгасугай.

ДАРГА





Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2025 оны 12 дугаар сарын 31-өдрийн
151 дүгээр тушаалын хавсралт

Бүртгэх хөрөнгийн жагсаалт

2025 оны 12 дугаар сарын 31

Улаанбаатар хот

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн	Зураг
1	2	3	4	5	6	7
1	Төхөөрөмж VR-3D газрын зураг	ш	1	69,000,000	69,000,000	
2	Цахим хуудас (visit-ulaanbaatar.com)	ш	1	29,575,000	29,575,000	
3	Аппликейшн (Visit Ub)	ш	1	29,275,000	29,275,000	
Нийт бүртгэх хөрөнгийн дүн					127,850,000	

